



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
2017 ОНЫ ТОЙМ**



**Улаанбаатар хот**

**2018 он**

**АГУУЛГА**

<b>1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>3</b>
1.1. Зах зээлийн үнэлгээ	3
1.2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	4
<b>2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД</b>	<b>5</b>
2.1. Хувьцаат компаниуд	5
2.2. Зохицуулалттай этгээд	8
<b>3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ</b>	<b>10</b>
3.1. Хөрөнгө оруулагчдын данс ба арилжааны бүтэц	10
3.2. Үнэт цаасны арилжаа	11
3.2.1. Хувьцааны арилжаа	11
3.2.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	11
3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	12
3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	12

**ЗУРАГ**

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/ .....	3
Зураг 2. ЗЗҮ-г ДНБ-нд харьцуулсан байдал .....	3
Зураг 3. Хөрвөх чадварын түвшин .....	4
Зураг 4. ТОП-20 индекс .....	4
Зураг 5. MSE ALL индекс.....	4
Зураг 6. Хувьцаат компанийн тоо.....	5
Зураг 7. Хороонд бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр .....	5
Зураг 8. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр.....	5
Зураг 9. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц, сая ширхэгээр .....	6
Зураг 10. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо.....	6
Зураг 11. Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн компанийн тоо .....	7
Зураг 12. Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо .....	7
Зураг 13. Тараасан ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/ .....	7
Зураг 14. Мэргэжлийн оролцогчдын тоо, тусгай зөвшөөрлийн чиглэлээр.....	8
Зураг 15. Нийт хөрөнгийн дүнг мэргэжлийн оролцогчдын тоотой харьцуулсан байдал.....	8
Зураг 16. Мэргэжлийн оролцогчдын тоо ба Эздийн өмч, Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн.....	9
Зураг 17. Мэргэжлийн оролцогчдын тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал.....	9
Зураг 18. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо.....	9
Зураг 19. Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер .....	10
Зураг 20. ҮЦТХТ-д шинээр нээгдсэн дансны тоо.....	10
Зураг 21. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь.....	10
Зураг 22. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт.....	11
Зураг 23. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/ .....	11
Зураг 24. ЗГҮЦ-ны нийт арилжааны дүн ба түүнд эзлэх хоёрдогч ЗЗ-ийн арилжааны хувь .....	12
Зураг 25. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ-д бүртгэгдсэн) гаргасан байдал.....	12
Зураг 26. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/.....	13
Зураг 27. МАРИХ индекс.....	13

**ХАВСРАЛТ**


Хавсралт 1. Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд .....	14
Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид.....	15
Хавсралт 3. Зах зээл дэх бүтээгдэхүүний эрэлт ба нийлүүлэлт.....	17

## 1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 1.1. Зах зээлийн үнэлгээ

2017 оны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээний нийлбэр дүн 2440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 966.1 тэрбум төгрөг буюу 65.5 хувиар өссөн үзүүлэлт юм.


Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны жилийн эцсийн байдлаар ЗЗҮ-г 2017 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 9.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 хувиар өссөн үзүүлэлт юм.


Зураг 2. ЗЗҮ-г ДНБ-нд харьцуулсан байдал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗЗҮ-нд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулж тооцсон, хөрвөх чадварын үзүүлэлт нь 3.2 хувь байна.

Зураг 3. Хөрвөх чадварын түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрвөх чадварын үзүүлэлт нь зах зээлийн идэвхийг харуулдаг бөгөөд энэ үзүүлэлт 3.2 хувь байгаа нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцааны 3.2 хувьтай тэнцэх хэмжээний арилжаа хийгдсэнийг харуулж байна.

### 1.2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66.5 хувиар өсч 20736.93 нэгж болсон бөгөөд нидексийн дээд үзүүлэлт 24520.35 нэгж, доод үзүүлэлт 11972.11 нэгж, дундаж үзүүлэлт 15511.89 нэгж байна.


Зураг 4. ТОП-20 индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд MSE ALL индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.1 хувиар өсч 1146.31 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 1280.32 нэгж, доод үзүүлэлт 814.51 нэгж, дундаж үзүүлэлт 950.09 нэгж байна.

Зураг 5. MSE ALL индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## 2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

### 2.1. Хувьцаат компаниуд

2017 оны жилийн эцсийн байдлаар 300 хувьцаат компани Хороонд бүртгэлтэй байна. Энэ онд хоёр компани үнэт цаасаа анх удаа олон нийтэд санал болгон гаргасан.


Зураг 6. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хороонд бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл, 250 хувьцаат компани буюу 83 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.


Зураг 7. Хороонд бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Арилжаа эрхлэх байгууллагуудад бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 219 хувьцаат компанийн 188 буюу 86 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.

Зураг 8. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компани, өмчийн хэлбэрээр




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд бүртгэлтэй хувьцаат компанийн тоо зөрүүтэй байгаа явдал нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар арилжаа эрхлэх байгууллага бүртгэлийн журмаа боловсруулж, Хороогоор батламжуулж, журмын хүрээнд бүртгэлийн шалгуур шаардлагыг тогтоох, бүртгэлийн шаардлага хангаагүй бүртгэлтэй компанийг өөрийн бүртгэлээс хасдаг.

Хорооны хувьд өөрийн эрх зүйн байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан хувьцаат компанийг өөрийн бүртгэлээс шууд хасах боломжгүй бөгөөд хөрөнгийн үнэлгээнд тулгуурлан нэгж хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг гаргуулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөхгүй, гомдол гаргахгүй нөхцөл бүрдсэн нөхцөлд үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах шийдвэр гаргадаг нь хоёр байгууллагын бүртгэлийн зөрүүтэй байдлыг үүсгэдэг.

Хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 83-аас 86 хувь нь хувийн өмчит байсан бол хувьцааны хэмжээгээр харьцуулж үзэхэд 62 хувь нь хувийн өмчид харьяалагдаж байна.


**Зураг 9. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц, сая ширхэгээр**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК


Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын гаргасан зохицуулалтын гурван үндсэн зорилгод зохицуулагч байгууллага ил тод, үр ашигтай, өрсөлдөөн бүхий зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг. Манай өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл тайлагналын ил тод байдал гэдэгт санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулсан болон ногдол ашиг тараалтын байдлыг хамруулан ойлгодог.

**Зураг 10. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Зураг 11. Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн компанийн тоо**




2016, 2017 оны ногдол ашиг тараалтын дүнг харьцуулан үзэхэд ногдол ашиг тараасан компанийн тоо өөрчлөлтгүй байгаа ч тараасан ногдол ашгийн хэмжээ 2016 оноос 2017 онд нэмэгдсэн байна.

**Зураг 12. Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо**



Манай орны хөрөнгийн зах зээлийн хувьд ногдол ашиг тараасан компанийн тоог нийт бүртгэлтэй хувьцаат компаниудын тоотой харьцуулахад 10 хүрэхгүй хувь нь ногдол ашиг тарааж байгаа бөгөөд тараасан хөрөнгийн дүн огцом савалгаатай, уул уурхай, боловсруулах салбарын аж ахуйн нэгжүүд болох “Таван толгой”, “АПУ” ХК зэрэг компаниудын тараалтын хэмжээ ихээхэн нөлөөлж байна.

**Зураг 13. Тараасан ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/**






## 2.2. Зохицуулалттай этгээд

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу Хороонд бүртгүүлсний үндсэн дээр болоод Хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хувийн хөрөнгө оруулалтын сан 9, хөрөнгө оруулалтын менежментийн 17 компани байна.

2017 онд үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 52 компани мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байна.


**Зураг 14. Мэргэжлийн оролцогчдын тоо, тусгай зөвшөөрлийн чиглэлээр**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоол 2017 оноос хэрэгжиж эхэлсэн явдал нь мэргэжлийн оролцогчдын нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн дүнд тус тус эерэг нөлөө үзүүлжээ.

**Зураг 15. Нийт хөрөнгийн дүнг мэргэжлийн оролцогчдын тоотой харьцуулсан байдал**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


**Зураг 16. Мэргэжлийн оролцогчдын тоо ба Эздийн өмч, Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагаа нэмэгдэхэд зардлын бууралт гол нөлөө үзүүлсэн.

**Зураг 17. Мэргэжлийн оролцогчдын тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үүний зэрэгцээ үнэт цаасны зах зээлд оролцогч компаниудад үйлчилгээ үзүүлэх, Хороонд бүртгэлтэй хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний компаниуд үйл ажиллагаа явуулж байна.


**Зураг 18. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дагуу Хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх 1, болон брокерын 16 компани байна.

**Зураг 19. Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

#### 3.1. Хөрөнгө оруулагчдын данс ба арилжааны бүтэц

ҮЦГХТ ХХК-д өссөн дүнгээр нийт 906,116 данс, 143,244 холболтын данс байгаа бөгөөд 2017 онд нийт 19,544 данс шинээр нээгджээ.


**Зураг 20. ҮЦГХТ-д шинээр нээгдсэн дансны тоо**



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

2013 оноос эхлэн эдийн засгийн нөхцөл байдал, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал зэргээс хамааралтайгаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох хэмжээ буурсан байна.

**Зураг 21. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь**




Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

### 3.2. Үнэт цаасны арилжаа

2017 онд нийт 860.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 512.1 тэрбум төгрөгөөр буюу 147 хувиар өсчээ.

Зураг 22. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

#### 3.2.1. Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-иар хөрөнгийн биржээр нийтдээ 135 компанийн 134.1 сая ширхэг хувьцааг 78.13 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 29.1 тэрбум төгрөг буюу 59 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 23. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

#### 3.2.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

**Анхдагч зах зээлийн арилжаа:** 2017 онд нийт 44 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

**Хоёрдогч зах зээлийн арилжаа:** ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 1.4 сая ширхэг үнэт цаас 142.3 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

**Зураг 24. ЗГҮЦ-ны нийт арилжааны дүн ба түүнд эзлэх хоёрдогч ЗЗ-ийн арилжааны хувь**




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

### 3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Хороо нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагчид тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэхдээ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын дагуу хянадаг. 2017 онд “МИК актив ТЗК 12-14” ХХК-д тусгай зөвшөөрөл олгож, үнэт цаасыг бүртгэсэн.

**Зураг 25. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ-д бүртгэгдсэн) гаргасан байдал**




Эх сурвалж: МИК холдинг ХК

### 3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

2017 оны байдлаар Хөдөө аж ахуйн биржийн арилжаагаар 163 удаагийн спот арилжаа зохион байгуулж, 961 удаагийн хэлцлээр 6 955.7 тонн ноолуурын, 10 887.6 тонн хонины ноосны, 355.5 тонн тэмээний ноосны, 1 674.1 тонн ямааны завод ноосны, 1 206.7 тонн хонины завод ноосны гэрээг тус тус арилжиж, нийт 572.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.


**Зураг 26. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/**



Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж ХХК

Тус биржээр 2017 оны байдлаар нийт 960 хэлцлийн 572.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэний 163.8 тэрбум төгрөгийн гэрээний төлбөр тооцоо биржээр, 408.7 тэрбум төгрөгийн төлбөр тооцоо клирингийн эрхтэй брокерийн компаниудаар дамжин хийгдсэн байна.

**Зураг 27. MAPIX индекс**



Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж ХХК

2017 оны 12 сарын 19 өдөр анхны форвард гэрээний арилжааг Монгол улсад анх удаа Хөдөө аж ахуйн бирж зохион байгуулж, 11.5 тонн ноолуурыг ирээдүйд худалдах, худалдан авах хэлцэл хийсэн.

--oOo--

**Хавсралт 1. Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд**

1. Зах зээлийн үнэлгээ, ДНБ, Хувьцааны арилжааны статистик үзүүлэлт

(тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Зах зээлийн үнэлгээ	1 373.95	2 168.57	1 799.90	1 670.53	1 442.66	1 262.50	1 474.17	2 440.32
ДНБ	9 756.59	13 173.76	16 688.42	19 174.24	22 227.05	23 150.39	23 935.85	27 167.03
Хувьцааны арилжааны дүн	62.87	109.11	144.75	97.59	24.24	30.48	49.05	78.13

2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

(дундаж)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
MSE-ALL индекс						872.04	813.55	1 190.69
ТОП-20 индекс	14 331.30	19 846.67	16 839.10	15 874.02	14 832.98	12 278.99	11 605.7	22 108.55

Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид

3. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр

Жил	Хороонд бүртгэлтэй			Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй		
	Хувийн өмчит	Төрийн өмчийн оролцоотой	Төрийн өмчит	Хувийн өмчит	Төрийн өмчийн оролцоотой	Төрийн өмчит
2014	262	11	30	201	15	21
2015	258	12	30	198	16	21
2016	245	25	32	199	16	21
2017	250	19	31	188	12	19

4. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц (сая ширхэг)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Төрийн мэдлийн бус хувьцаа	1.88	0.39	2.01	1.98	2.28	2.28	2.84	2.85
Төрийн мэдлийн болон орон нутгийн оролцоотой хувьцаа	1.03	2.56	2.67	2.6	2.91	2.81	4.16	4.63

5. Хувьцаат компаниудын засаглалын үзүүлэлтүүд

Огноо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан хувьцаат компанийн тоо	Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн	Ногдол ашиг тараасан хувьцаат компанийн тоо	Тараасан ногдол ашгийн үнийн дүн /тэрбум төгрөг/
2005	139	152	18	0.83
2006	111	143	23	3.82
2007	119	138	28	7.35
2008	120	138	38	17.6
2009	114	121	26	14.3
2010	109	65	16	30.8
2011	124	59	28	74.3
2012	193	163	29	79.1
2013	158	204	30	11.4
2014	181	196	27	52.2
2015	133	173	23	7.3
2016	121	140	27	14.9
2017	142	123	27	69.5



6. Мэргэжлийн оролцогчдын тоо

(тусгай зөвшөөрлийн чиглэлээр)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Брокер, дилер	51	88	95	87	66	61	62	52
Андеррайтер	16	22	25	25	24	22	25	22
Хөрөнгө оруулалтын зөвлөх	8	17	18	18	15	16	15	14
ХАА-н түүхий эдийн брокер					36	37	37	16
Аудитын компани					25	36	44	49
Үнэлгээний компани					15	20	20	21
Хуулийн компани					12	17	19	21

7. Мэргэжлийн оролцогчдын санхүүгийн үзүүлэлтүүд

(тэрбум төгрөг)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт актив	18.37	42.28	43.34	64.88	57.32	67.95	91.28	91.79
Эздийн өмч	13.99	29.40	30.19	38.07	49.90	61.58	66.80	67.95
ХНХ	10.23	22.29	22.17	30.63	36.81	46.51	49.07	51.76
Тайлант үеийн ашиг, алдагдал	0.43	1.05	1.15	1.38	0.37	0.75	1.01	1.06

Хавсралт 3. Зах зээл дэх бүтээгдэхүүний эрэлт ба нийлүүлэлт

8. “ҮЦТХТ” ХХК-д нээгдсэн дансны тоо

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Шинэ данс	6 156	108 909	106 172	9 137	10 540	4 698	81 017	19 554
Холболтын данс	3 528	14 660	8 764	2 172	1 990	643	3 825	4 027

9. Хөрөнгө оруулагчдын арилжааны дүн

(тэрбум төгрөг)

Жил	Нийт арилжааны гүйлгээний дүн	Үүнээс:			
		Гадаадын ААН	Гадаадын иргэн	Дотоодын ААН	Дотоодын иргэн
2006	18.03	4.26	0.60	6.82	6.34
2007	102.39	33.83	4.52	46.91	17.13
2008	62.35	10.34	4.16	11.48	36.37
2009	23.18	6.05	0.90	6.37	9.86
2010	92.89	48.96	7.61	29.12	7.20
2011	350.24	91.36	11.14	225.96	21.78
2012	145.06	131.65	2.74	2.52	8.15
2013	98.61	10.97	2.10	79.55	5.99
2014	60.36	3.82	3.14	33.75	19.66
2015	546.40	3.33	5.91	510.03	27.14
2016	348.68	1.79	6.52	312.46	27.90
2017	860.8	10.59	24.32	657.61	167.71

10. Үнэт цаасны арилжааны дүн

(тэрбум төгрөг)

Жил	Нийт арилжааны гүйлгээний дүн	Үүнээс:			
		Засгийн газрын бондын гүйлгээний дүн /анхдагч/	Засгийн газрын бондын гүйлгээний дүн /хоёрдогч/	Хувьцааны гүйлгээний дүн	Компанийн бондын гүйлгээний дүн
2010	92.9	30.00	-	62.87	-
2011	350.2	236.73	-	109.11	4.39
2012	145.1	-	0.00	144.75	0.31
2013	98.6	-	1.01	97.59	-
2014	60.4	36.12	-	24.24	-
2015	546.4	510.34	5.12	30.48	0.50
2016	348.7	280.45	19.19	49.05	-
2017	860.8	630.20	142.34	78.13	10.16

11. Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас

Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,29
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,51
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	96.3	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	67.5	1,135
“МИК актив арван хоёр ТЗК” ХХК	272.3	262.4	4,439
“МИК актив арван гурав ТЗК” ХХК	190.3	190.2	3,039
“МИК актив арван дөрөв ТЗК” ХХК	145.3	139.2	2,340

12. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн

(тэрбум төгрөг)

	2013	2014	2015	2016	2017
Арилжааны хэмжээ	403.60	554.09	431.69	463.00	572.55